



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

*МОНГОЛ УЛСЫН ЗАМ,  
ТЭЭВЭР*

*2021  
1 улирал*

*СТАТИСТИКИЙН  
МЭДЭЭЛЭЛ*

## Агуулга

<b>I. Монгол Улсын зам, тээврийн салбарын статистик .....</b>	<b>3</b>
1.Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт .....	3
1.1. Зорчигч тээвэрлэлт .....	3
1.2. Зорчигч эргэлт .....	3
1.3. Ачаа тээвэрлэлт .....	5
1.4. Ачаа эргэлт .....	5
1.5. Тээврийн орлого .....	7
1.6. Гадаад худалдаа, тээврийн төрлөөр .....	8
2. Автотээврийн салбар .....	9
2.1. Авто замын хилийн боомтуудаар нэвтэрсэн ачаа урсгалын мэдээ .....	10
2.2. Автотээврээр тээвэрлэсэн зорчигч тээвэрлэлт .....	12
2.2.1. Авто замын хилийн боомтуудаар нэвтэрсэн зорчигч тээвэрлэлт.....	12
2.2.2. Хот хоорондын зорчигч тээвэрлэлт .....	13
2.3. Авто үйлчилгээний ангилал тогтоолгын мэдээлэл .....	14
2.3.1. Авто үйлчилгээний нэр төрөл .....	15
3. Иргэний нисэхийн салбар .....	16
3.1. Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа болон шуудан тээвэрлэлт .....	17
3.2. Агаарын тээврээр тээвэрлэсэн зорчигч урсгалын мэдээ .....	18
3.2.1.Олон улсын зорчигч тээвэрлэлт, тээвэрлэгч байгууллагуудын чиглэл тус бүрээр .....	19
3.2.2.Орон нутгийн зорчигч тээвэрлэлт, тээвэрлэгч байгууллагуудын чиглэл тус бүрээр .....	20
3.3. Нислэгийн тоон үзүүлэлт .....	21
4. Төмөр замын салбар .....	22
4.1. Төмөр замаар тээвэрлэсэн ачаа тээвэрлэлт .....	23
5. Бүх төрлийн тээврийн хэрэгслийн импортын мэдээ .....	26
<b>II. Дүгнэлт .....</b>	<b>28</b>

## I. МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН 2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН СТАТИСТИК

### 1. Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт<sup>1</sup>

#### 1.1. Зорчигч тээвэрлэлт

Тээврийн төрөл	2020 I улирал	2021 I улирал	2021.I/2020.I харьцуулалт, %
<b>Нийт зорчигч тээвэрлэлт, сая хүн</b>	29.1	19.8	68.1
Үүнээс:			
Автотээвэр, сая хүн	28.5	19.8	69.6
Төмөр зам, мянган хүн	444.83	-	-
дотоодод	435.62	-	-
гадаад руу	9.21	-	-
Агаарын тээвэр, мянган хүн	215.8	25.2	11.6
дотоодод (орон нутгийн)	85.48	18.2	21.3
олон улсад	130.32	6.9	5.3

#### 1.2. Зорчигч эргэлт

(сая хүн-км)

Тээврийн төрөл	2020 I улирал	2021 I улирал	2021.I/2020.I харьцуулалт, %
<b>Нийт зорчигч тээвэрлэлт, сая хүн-км</b>	1016.03	332.1	32.7
Үүнээс:			
Автотээвэр	445.8	309.7	69.6
Төмөр зам	148.5	-	-
Агаарын тээвэр	421.73	22.4	5.3
дотоодод	52.56	9.4	17.9
олон улсад	369.17	13	3.5


<sup>1</sup> Зам, тээврийн салбарын үндсэн үзүүлэлтийн сар бүрийн мэдээллийг YCSX-д хүргүүлдэг.

## Зорчигч тээвэр

Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улсад хэд хэдэн удаа хатуу хөл хорио тогтоож гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан гадаад болон дотоод зорчигч тээвэрлэлтийн хөдөлгөөнийг хязгаарласан нь зорчигч тээвэрлэлтийн бууралтад шууд нөлөөлсөн. Бүх төрлийн тээврээр зорчигчид давхардсан тоогоор 19.8 сая хүн болж. өмнөх оны мөн үеэс зорчигч 9.3 сая хүн буюу 30.4%-иар буурсан байна. Энэхүү бууралтад нийслэл дэх нийтийн автотээврээр үйлчлүүлэгчдийн тоо буурсан нь голлон нөлөөлжээ. 2018-2021 онуудын эхний улирлын зорчигч тээвэрлэлтийг График 1-т үзүүлэв. Үүнд:

- Автотээврээр 2021 оны эхний улиралд давхардсан тоогоор 19.8 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос зорчигчид 8.7 сая хүн буюу 30.4%-иар буурсан байна. Үүний гол шалтгаан нь нийслэлийн нийтийн тээврээр зорчсон зорчигчдын тоо буурсан нь голлон нөлөөлсөн байна.
- Төмөр замын тээврээр 2021 оны эхний улиралд зорчигч тээвэрлээгүй.
- Агаарын тээврээр 2021 оны эхний улиралд зорчигчид 25.2 мянган хүн болж. өмнөх оноос зорчигчид 190.6 сая хүн буюу 88.3%-иар буурчээ.

**График 1. Зорчигч тээвэр, сая хүн**



### 1.3. Ачаа тээвэр

Тээврийн төрөл	2020 I улирал	2021 I улирал	2021.I/2020.I харьцуулалт. %
<b>Нийт ачаа тээвэрлэлт, мянган тонн</b>	<b>10236.5</b>	<b>17451.8</b>	<b>170.6</b>
Үүнээс:			
Автотээвэр, мянган тонн	3124.59	9318.4	298
Төмөр зам, мянган тонн	7090.43	8132.7	114.7
дотоодод	2537.54	3360.19	132.4
экспорт (гаргалт)	3099.52	2847.46	91.9
импорт (оруулалт)	615.29	888.04	144.3
дамжин өнгөрсөн	838.08	1037.01	123.7
Агаарын тээвэр, тонн	1 083.31	731.3	67.5
дотоодод (орон нутаг)	22.29	0.5	2.2
олон улсад	1061.02	730.8	68.9

### 1.4. Ачаа эргэлт

Тээврийн төрөл	2020 I улирал	2020 I улирал	2021.I/2020.I харьцуулалт. (сая тонн-км) %
<b>Нийт ачаа эргэлт, сая тонн-км</b>	<b>8421.92</b>	<b>8276.9</b>	<b>98.3</b>
Үүнээс:			
Автотээвэр, сая тонн-км	639.98	1908.6	298
Төмөр зам, сая тонн-км	4447	4657.26	104.7
дотоодод	673.9	817.88	121.4
гадаадад (гаргалт)	2533.91	2281.43	90
гадаадаас (оруулалт)	308.91	406.85	131.7
дамжин өнгөрсөн	930.27	1151.09	51.3
Агаарын тээвэр, сая тонн-км	3334.94	1711	51.3
дотоодод	20.97	3	14.3
олон улсад	3313.96	1708	51.5


### Aчаа тээвэр

Зам. тээврийн салбар 2021 эхний улиралд бүх төрлийн тээврээр нийт 17.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2 сая тонн буюу 70.5%-иар өссөн.

Нийт ачаа тээврийн 53.4%-ийг автотээврээр, 46.6%-ийг төмөр замын тээврээр тээвэрлэсэн байна. Авто тээврээр тээсэн ачаа 6.2 сая тонноор өссөн нь бүх төрлийн тээврийн өсөлтөд голлон нөлөөлжээ. Өмнөх онуудын мөн үеийн үзүүлэлтийг График 2-аар үзүүлэв.

- Автотээврээр 2021 оны эхний улиралд 9.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс тээвэрлэсэн ачаа 6.2 сая тонн буюу 3 дахин өссөн байна.
- Төмөр замаар 2021 оны эхний улиралд 8.1 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 1 сая тонн буюу 14.7%-иар өссөн байна. Төмөр замын нийт ачаа тээвэрлэлтэд дотоодын ачаа 3.4 сая тонн буюу 42%, экспортын ачаа 2.8 сая буюу 34.6%, импортын ачаа 0.9 сая тонн буюу 11.1%, дамжин өнгөрсөн ачаа 1 сая тонн буюу 12.3%-ийг тус тус эзэлж байна.
- Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа 2021 оны эхний улиралд 731.3 тонн болж, өмнөх оны мөн үеэс тээвэрлэсэн ачаа 352 тонн буюу 32.5%-иар буурсан байна.

**График 2. Ачаа тээвэрлэлт, мян.тн**



## 1.5. Тээврийн орлого

Тээврийн төрөл	2020 I улирал	2021 I улирал	(тэрбум төгрөг) 2021.I/2020.I харьцуулалт, %	
				%
<b>Тээврийн нийт орлого</b>	311.9	352.7	113.1	
Автотээвэр	85.9	136.3	158.6	
Төмөр зам	174.1	191.3	109.9	
Агаарын тээвэр	51.9	25.1	48.4	


### Тээврийн орлого

Зам. тээврийн салбарын 2021 оны эхний улирлын тээврийн нийт орлого 352.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 40.8 тэрбум төгрөг буюу 13.1%-иар өссөн бол өмнөх улирлаас 98.1 тэрбум төгрөг буюу 21.8%-иар буурсан байна.

Нийт орлогын 54.2%-ийг төмөр зам. 38.6%-ийг автотээвэр. 7%-ийг агаарын тээврийн салбар тус тус бүрдүүлсэн байна. 2018-2021 онуудын эхний улирлын тээврийн орлогыг график 3-аар үзүүлэв. Үүнд:

- Автотээврийн 2021 оны эхний улирлын орлого 136.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 50.4 тэрбум төгрөг буюу 58.6%-иар өссөн боловч өмнөх улирлаас 77.6 тэрбум төгрөг буюу 36.3%-иар буурсан байна.
- Төмөр замын тээврийн 2021 оны энхийн улирлын тээврийн орлого 191.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17.2 тэрбум төгрөг буюу 9.9%-иар өссөн байна. Өсөлтөд барилгын материал. хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болон түргэн муудах бүтээгдэхүүний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Төмөр замын тээврийн орлого 2021 оны 3 дугаар сард өмнөх сараас 11.1 тэрбум төгрөг буюу 19%-иар өсөж 69.5 тэрбум төгрөг болсон байна.
- Агаарын тээврийн 2021 оны эхний улирлын үндэсний тээвэрлэгчдийн орлого 25.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 26.8 тэрбум төгрөг буюу 51.6%-иар буурсан байна. Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2021 оны 3 дугаар сард өмнөх сараас 605.6 сая төгрөг буюу 7.3%-иар буурч 7.7 тэрбум төгрөг болсон байна.

**График 3. Тээврийн орлого, тэрбум төгрөг**



**1.6. Гадаад худалдаа, тээврийн төрлөөр<sup>2</sup>**

(мянган доллар)

Тээврийн төрөл	Импорт, үнийн дүн		Экспорт, үнийн дүн	
	2020 Г улирал	2021 Г улирал	2020 Г улирал	2021 Г улирал
Төмөр зам	650099.77	838432.42	491310.20	724961.41
Авто зам	412413.87	573775.43	452476.37	1220240.48
Агаар	59448.26	66459.20	91826.25	5055.06
Шуудан илгээмж	72.21	43.72	9.79	12.64
Буухиа шуудан	215.92	4.38	19.46	33.81
Холимог тээвэр	0.00	1.71		
Хөдөлгөөнт бус тээвэр	38679.60	44978.13	160.59	100.18
Бусад тээврийн хэрэгсэл	634.52	0.00		
<b>Дүн</b>	<b>1161564.1</b>	<b>1523695.0</b>	<b>1035802.6</b>	<b>2000403.6</b>

2021 оны эхний улиралд бүх төрлийн тээврээр хийсэн импортын гадаад худалдаа өмнөх оны мөн үеэс 31.2%-иар, экспорт 93%-иар өссөн байна. Дээрх хүснэгтээс харахад бүх төрлийн тээврээр хийсэн гадаад худалдааны хэмжээ өмнөх оныхоос өссөн байна. БНХАУ-аас ковид-19 цар тахал илэрч дэлхий дахинд дэгдэж Монгол Улс 2020 оны эхний улиралд хатуу хөл хорио тогтоон хилээ хааснаар ачаа болон зорчигч тээвэрлэлт огцом буурсан үзүүлэлттэй гарсан. Жилийн хугацаанд тээврийн салбар нь барагүй бэрхшээлийг туулж үйл ажиллагаагаа тогтвортой. найдвартай явуулахын тулд цаг алдалгүй зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж чадсанаар зарим үзүүлэлтүүдийг нэмэгдүүлж чадсан. Ингэснээр 2021 оны эхний улирлын ачаа тээвэрлэлт, гадаад худалдааг өмнөх оны мөн үеэс нэмэгдүүлсэн байна.

<sup>2</sup> ГЕГ-ын 2021.01-03 дугаар сарын статистик мэдээлэл

# АВТОТЭЭВРИЙН САЛБАР




## 2. Автотээврийн салбар

### 2.1. Авто замын хилийн боомтоор нэвтэрсэн ачаа урсгалын мэдээ<sup>3</sup>


№	Боомтын нэр	Зай /км/	2021 оны I улирал			(тонн)
			Экспорт	Импорт	Нийт	
1	Алтанбулаг	360	-	6265	6265	
2	Бичигт	80	169304	-	169304	
3	Баянхошуу-Өвдөг	640	112934	-	112934	
4	Бургастай	80	-	-	-	
5	Гашуун сухайт	239	2755756	-	2755756	
7	Замын -ҮҮД	7	52009	219502	271511	
8	Цагаан нуур	100	-	14726	14726	
9	Хавирга-Ар хашаат		-	-	-	
10	Ханги	20	394619	-	394619	
11	Шивээ хүрэн	65	1973156	-	1973156	
12	Ярант	350	280108	-	280108	
<b>НИЙТ ДҮН</b>			<b>5737886</b>	<b>240493</b>	<b>5978379</b>	

<sup>3</sup> “АТҮТ” ТӨҮГ-ын мэдээлэл. Сар бүрийн мэдээг дараа сарын 15-ны өдрийн дотор гаргаж ЗТХЯ-д ирүүлдэг.

Автотээврээр 2021 оны эхний улиралд 9.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 6.2 сая тонн буюу 3 дахин өссөн байна. Ачаа тээврийн өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 5.9 сая тонн буюу 3.4 дахин өссөн нь нөлөөлсөн байна. Автотээврээр тээвэрлэсэн ачаа өмнөх улирлаас 3.3 сая тонн буюу 25.6%-иар буурсан байна. 2021 оны эхний улирлын ачаа тээвэрлэлтийг 2019, 2020 онтой харьцуулсныг График 4-д харуулав.



Автотээврийн салбар 2021 оны эхний улиралд давхардсан тоогоор 19.8 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигчийн тоо 8.7 сая хүн буюу 30.4%-иар, өмнөх улирлаас 6.3 сая хүн буюу 24.2%-иар тус тус буурсан байна. Улаанбаатар нийслэл хотод удаа дараалан хөл хорио тогтоосон тул нийтийн тээврээр зорчигчдын тоо буурсан нь голлон нөлөөлсөн байна. Бууралтын үзүүлэлтийг өмнөх онуудтай График 5-д харьцуулав.



## 2.2. Автотээврээр тээвэрлэсэн зорчигч тээвэрлэлтийн хэмжээ

### 2.2.1. Авто замын боомтуудаар нэвтэрсэн зорчигчдын тоо<sup>4</sup>

Боомтын нэр	2021 оны I улирал		Нийт
	Орсон	Гарсан	
	БНХАУ-ЫН ШУӨЗО		
Булган	3975	3975	7950
Байтаг	0	0	0
Бургатай	0	0	0
Даян	0	0	0
<b>Дүн</b>	<b>3975</b>	<b>3975</b>	<b>7950</b>
БНХАУ-ЫН ӨМӨЗӨ			
Бичигт	3295	3295	6590
Баянхошуу	3095	3095	6190
Гашуунсухайт	32368	32368	64736
Шивээхүрэн	23644	23644	47288
Замын-Үүд	10997	11475	22472
Сүмбэр	0	0	0
Хавирга	0	0	0
Ханги	4875	4875	9750
<b>Дүн</b>	<b>78274</b>	<b>78752</b>	<b>157026</b>
ОХУ			
Алтанбулаг	1594	1657	3251
Арцсуурь	0	0	0
Боршоо	88	88	176
Цагаан нуур	616	616	1232
Ханх	0	0	0
Ульхан	0	0	0
Эрээнцав	0	0	0
Шарсуурь/тэс/	0	0	0
<b>Дүн</b>	<b>2298</b>	<b>2361</b>	<b>4659</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>84547</b>	<b>85088</b>	<b>169635</b>

Авто замын боомтуудаар нэвтэрсэн зорчигч тээвэрлэлт 169635 болж өмнөх оны мөн үеэс 217813 буюу 56.2%-иар, өмнөх улирлаас 58372 хүн буюу 25.6%-иар тус тус буурсан байна.

<sup>4</sup> “АТҮТ” ТӨҮГ-ЫН 2020 оны жилийн эцсийн мэдээлэл. Сар бүрийн мэдээг дараа сарын 15-ны өдрийн дотор ЗТХЯ-д ирүүлдэг.

**2.2.2. Хот хоорондын зорчигч тээвэрлэлт<sup>5</sup>**

№	Аймгийн нэр	Сум дүүргийн нэр	Тээвэр лэлтийн зайд	Суудал ашиглалт	РЕЙС	Өссөн дүн			Зорчигч эргэлт /хүн*км/
						ЗОРЧИГЧ	УБ-аас гарсан	УБ-т ирсэн	
1	Архангай	Цэцэрлэг	560	0.68	38	30	38	68	38.080
		Эрдэнэбулган	486	0.72	885	401	611	1.012	91.832
		Тариат	647	0.56	119	21	63	84	54.348
		Жаргалант	571	0.77	40	12	0	12	6.852
2	Баян-Өлгий	Өлгий-сум	1709	0.67	497	173	659	832	1.421.888
3	Баянхонгор	Баянхонгор	640	0.90	1.018	415	512	927	593.280
4	Булган	Гурванбулаг	296	0.41	113	10	13	23	6.808
		Булган	438	0.92	37	128	106	234	102.492
5	Говь-Алтай	Есөнбулаг	1037	0.83	669	225	445	670	694.790
		Бигэр	997	0.49	45	0	4	4	3.988
6	Дархан-Уул	Дархан	219	0.72	2.240	1.209	1.211	2.420	529.980
		Шарын гол	209	0.78	223	99	70	169	35.321
7	Дорнод	Баян-Уул	600	0.84	31	47	63	110	66.000
		Хэрлэн сум	658	0.82	485	289	364	653	429.674
		Дашбалбар	756	0.87	44	13	18	31	23.436
		Сайхан Овоо	505	0.61	77	11	22	33	16.665
8	Дундговь	Сайнцагаан	275	0.56	450	74	116	190	52.250
		Улиастай	1023	0.72	680	20	109	129	31.967
9	Завхан	Тосонцэнгэл	838	0.72	281	0	80	80	67.040
		Бат-Өлзий	433	0.65	58	26	67	93	40.269
10	Орхон	Баян-Өндөр	378	0.59	1.351	892	887	1.779	672.462
		Арвайхээр	431	0.71	1.183	300	550	850	366.350
11	Өвөрхангай	Хужирт	384	0.79	319	128	134	262	100.608
		Есөнзүйл	368	0.68	31	4	16	20	7.360
		Хархорин	365	0.56	530	131	174	305	111.325
		Сант	409	0.69	77	9	15	24	9.816
		Бат-Өлзий	433	0.65	58	26	67	93	40.269
		Даланзадгад	575	0.54	533	69	77	146	83.950
		Цогтцэций	544	0.86	1.068	309	533	842	458.048
		Сайншанд	450	0.66	308	314	339	653	293.850
		Баруун-Урт	565	0.68	575	120	267	387	218.655
		Дарьганга	710	0.82	118	21	55	76	53.960
12	Өмнөговь	Эрдэнэцагаан	768	0.59	85	26	22	48	36.864
		Алтанбулаг	343	0.66	287	157	160	317	108.731
13	Дорнговь	Зуунмод	43	0.57	2.361	72	103	175	7.525
		Заамар	183	0.52	141	3	3	6	1.098
		Жаргалант	128	0.79	220	12	63	75	9.600
		Борнуур	90	0.49	174	7	0	7	630
		Шижир-Алт	260	0.56	186	28	17	45	11.700
		Батсүмбэр	79	0.73	547	99	137	236	18.644
		Хо.Жаргалант	1488	0.73	773	286	491	777	1.156.176
14	Сүхбаатар	Хо.Булган	1720	0.59	171	35	118	153	263.160
		Чингис	338	0.66	581	214	251	465	157.170
		Батноров	443	0.76	78	9	7	16	7.088
15	Хэнтий	Бор-Өндөр	348	0.40	156	83	98	181	62.988
		Мөрөн	788	0.65	1.990	633	1255	1.888	1487.744
		Галт	920	0.62	32	17	-	17	15.640
16	Төв	Улаангом	1382	0.74	880	258	405	663	916.266
		Ув.Өмнөговь	1367	0.68	62	20	34	54	73.818
		Өндөрхангай	1165	0.66	42	0	27	27	31.455
		Зүүнговь	1280	0.85	49	10	43	53	6.840
<b>НИЙТ ДҮН</b>		<b>42573</b>	<b>0.73</b>	<b>30.499.5</b>	<b>7469</b>	<b>10852</b>	<b>18.321</b>	<b>11617481</b>	

<sup>5</sup> “АТҮТ” ТӨҮГ-ын мэдээлэл. Сар бүрийн мэдээг дараа сарын 15-ны өдрийн дотор ЗТХЯ-д ирүүлдэг.

**2.3.Авто үйлчилгээний ангилал тогтоолгын 2021 оны эхний  
улирлын мэдээлэл<sup>6</sup>**

Үзүүлэлт		2021 оны I улирал		
		Орон нутаг	Улаанбаатар	Нийт
<b>1.Авто үйлчилгээний зөвшөөрөл олгосон-Бүгд</b>		<b>198</b>	<b>142</b>	<b>340</b>
A	A1 ангилал	18	1	19
	A2 ангилал	21	37	58
	A3 ангилал	8	8	16
	Нийт	47	46	92
	B1 ангилал	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
B	B2 ангилал	103	40	142
	B3 ангилал	0	0	0
	Нийт	103	40	142
	C1 ангилал	5	15	20
C	C2 ангилал	0	10	10
	C3 ангилал	43	31	74
	Нийт	48	56	104
<b>Ангилал тогтоолгосон авто үйлчилгээ эрхлэгчид –Бүгд</b>		<b>198</b>	<b>142</b>	<b>340</b>
A	A1	ААНБ	14	1
		Иргэн	4	0
		Нийт	18	1
	A2	ААНБ	10	25
		Иргэн	11	12
		Нийт	21	37
	A3	ААНБ	2	5
		Иргэн	6	3
		Нийт	8	8
		Нийт	47	46
B	B1	ААНБ	0	0
		Иргэн	0	0
		Нийт	0	0
	B2	ААНБ	33	13
		Иргэн	70	27
		Нийт	103	40
	B3	ААНБ	0	0
		Иргэн	0	0
		Нийт	0	0
		Нийт	103	40
C	C1	ААНБ	4	14
		Иргэн	1	1
		Нийт	5	15
	C2	ААНБ	0	7
		Иргэн	0	3
		Нийт	0	10
	C3	ААНБ	20	14
		Иргэн	23	17
		Нийт	43	31
		Нийт	48	56

<sup>6</sup> ЗТХС-ын 2019 оны 203 дугаар тушаалаар баталсан З-АТ-6 маягтын дагуу  
“АТҮТ” ТӨҮГ нь орон нутгийн мэдээг аймаг тус бүрээр, ННТҮГ нь Улаанбаатар  
хотын мэдээг дүүрэг тус бүрээр гаргаж ЗТХЯ-д улирал бүр ирүүлдэг.

### 2.3.1. Авто үйлчилгээний нэр төрөл<sup>7</sup>

Үзүүлэлт	2021 оны I улирал		
	Орон нутаг	Улаанбаатар	Нийт
<b>Авто үйлчилгээ эрхлэгчид- Бүгд</b>	<b>172</b>	<b>142</b>	<b>314</b>
Иргэн	104	64	167
ААНБ	68	78	145
<b>Авто үйлчилгээний зөвшөөрөл- Бүгд</b>	<b>198</b>	<b>142</b>	<b>340</b>
Агрегат засвар	44	47	90
Кузов засвар	1	0	1
Дугуй засвар	3	0	3
Авто угаалга	101	40	140
Автомашин, сэлбэг, хэрэгсэл, тос. тосолгооны болон ашиглалтын материал худалдаа	42	27	69
Авто зогсоол	6	0	6
Оёдол, доторлогоо	1	0	1
Бусад	0	28	28

Монгол Улсын хэмжээнд 2021 оны эхний улирлын байдлаар авто үйлчилгээний зөвшөөрөлтэй нийт 340 иргэн, ААНБ-ууд байна. Орон нутагт зөвшөөрөлтэй 198, Улаанбаатар хотод зөвшөөрөлтэй 142 иргэн, ААНБ-ууд үйлчилгээ явуулж байгаагаас 167 иргэн, 145 ААНБ байна.

Авто үйлчилгээний А ангилалын зөвшөөрөлтэй 92, В ангилалын зөвшөөрөлтэй 142, С ангилалын зөвшөөрөлтэй 104 иргэн, ААНБ-ууд байна.

<sup>7</sup> 3-АТ-6 маягтын үргэлжлэл

# ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР




### 3. Иргэний нисэхийн салбар<sup>8</sup>

#### 3.1. Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа болон шуудан тээвэрлэлтийн хэмжээ

2021 I-III сар	Ачаа			Шуудан			2021.I. ачаа + шуудан	(тонн) 2021.I/2020.I харьцуулалт. %
	Олон улс	Орон нутаг	Нийт	Олон улс	Орон нутаг	Нийт		
1 сар	212.4	0.3	212.7	15.5	0	15.5	228.2	51.3
2 сар	267.7	0.0	267.7	20.2	0	20.2	287.9	79.3
3 сар	200.0	0.2	200.2	15.0	0	15.0	215.2	46.8
<b>Нийт</b>	<b>680.1</b>	<b>0.5</b>	<b>680.6</b>	<b>50.7</b>	<b>0</b>	<b>50.7</b>	<b>731.3</b>	<b>67.5</b>

Агаарын тээврээр 2021 оны эхний улиралд 731.3 тн ачаа болон шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 352.0 тонн буюу 32.5%-иар буурсан байна. График 6-аас харахад нийт тээвэрлэсэн ачаа, шуудангаас олон улсад 730.8 тн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 330.2 тонн буюу 31.1%-иар буурч, орон нутагт 0.5 тн ачаа. шуудан тээвэрлэсэн нь 21.7 тн буюу 97.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.

График 6. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан, тонн




<sup>8</sup> ИНЕГ-ын 2021 оны эхний улирлын мэдээлэл. ИНЕГ нь сар бүрийн мэдээг дараа сарын 15-ны өдрийн дотор гаргаж ЗТХЯ-д ирүүлдэг.

### 3.2. Агаарын тээврээр тээвэрлэсэн зорчигч тээвэрлэлтийн мэдээ

2021 I-III сар	2020 оны I улирал			2021 оны I улирал			2021.I/2020.I харьцуулалт, %
	Олон улс	Орон нутаг	Нийт	Олон улс	Орон нутаг	Нийт	
1 сар	83268	32311	115579	1387	5846	7233	6.3
2 сар	40372	26623	66995	2173	5239	7412	11.1
3 сар	6682	26546	33228	3364	7155	10519	31.7
<b>Нийт</b>	<b>130322</b>	<b>85480</b>	<b>215802</b>	<b>924</b>	<b>18240</b>	<b>25164</b>	<b>11.7</b>

Агаарын тээврээр 2021 оны эхний улиралд нийт 25164 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 190638 зорчигчоор буюу 88.3%-иар, өмнөх улирлаас 28646 буюу 53.2%-иар тус тус буурсан. Харин 3 дугаар сард өмнөх сараас 3107 зорчигч буюу 41.9%-иар их зорчигч тээвэрлэсэн байна. Ковид 19 цар тахлын улмаас дэлхийн улс орнууд олон улсын зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа зогссон бөгөөд дотоод тээвэрлэлтийн үйл ажиллагаагаа ч хязгаарласан билээ. Энэхүү хязгаарлалтын улмаас агаарын тээврийн зорчигч тээвэрлэлт огцом буурсан үзүүлэлтийг График 7-оос харна уу.


График.7 Агаараар тээврийн зорчигч тээвэрлэлт, мян.хүн



### 3.2.1. Олон улсын зорчигч тээвэрлэлт, тээвэрлэгч байгууллагуудын чиглэл бүрээр

Агаарын тээвэрлэгч	Чиглэл	2021 И улирал
<b>МИАТ ТӨХК</b>	Бээжин Сөүл Токио Франкфурт Стамбул Нурсултан Перт Сингапур <b>НИЙТ</b>	- 3 512 746 538 477 168 125 80 <b>5 646</b>
<b>Аэро Монголиа ХХК</b>	Тяньжин <b>НИЙТ</b>	56 <b>56</b>
<b>Хүннү Эйр ХХК</b>	Кабул Доха Ташкент Дели Токио Алматы Екатеринбург <b>НИЙТ</b>	358 53 24 126 2 16 101 <b>680</b>
Кореан Эйр		315
Чarter		227
<b>НИЙТ</b>		<b>6 924</b>

**График 8. Тээвэрлэгч байгууллагуудын олон улсад зорчигч тээвэрлэсэн хувь**




Олон улсад зорчигчдын тоо эхний улиралд 6924 болж өмнөх оны мөн үеэс 123398 буюу 94.7%-иар буурсан. Харин өмнөх улирлаас 2543 зорчигч буюу 26.9%-иар буурсан. Олон улсад зорчигчдын 81.5% буюу 5645 зорчигчийг МИАТ ТӨХК тээвэрлэсэн бол “Аэро Монголиа” ХХК нь Тяньжин чиглэлд 56 зорчигч тээвэрлэсэн. “Хүннү Эйр” ХХК нь нийт 680 зорчигч тээвэрлэснээс Кабул чиглэлд 358 зорчигч, Доха чиглэлд 53 зорчигч, Ташкент чиглэлд 24 зорчигч, Дэли чиглэлд 126 зорчигч, Токио чиглэлд 2 зорчигч, Алматы чиглэлд 16, Екатеринбург чиглэлд 101 зорчигч тус тээвэрлэсэн байна. Гадаадын тээвэрлэгч Кореан Эйр 315 зорчигчийг 2021 оны эхний улиралд тээвэрлэснийг График 8-д үзүүлэв.

### 3.2.2. Орон нутгийн зорчигч тээвэрлэлт, тээвэрлэгч байгууллагуудын чиглэл бүрээр

Агаарын тээвэрлэгч	Чиглэл	2020 I улирал	2021 I улирал	2021.I/2020.I харьцуулалт. %
<b>Хүннү Эйр ХХК</b>	Чойбалсан	507	-	-
	Улаанбаатар	1 259	-	-
	Ховд	2 974	41	1.4
	Улаангом	1 721	-	-
	Өлгий	2 161	26	1.2
	Овоот	1 373	-	-
	Оюутолгой	16 797	2 704	16.1
	Оюутолгой- Даланзадгад	7 320	974	13.3
	Алтай	910	362	39.8
	Мөрөн	681	30	4.4
	<b>Нийт</b>	<b>35 703</b>	<b>4 137</b>	<b>11.6</b>
<b>Аэромонголиа ХХК</b>	Өлгий	917	225	24.5
	Алтай	2 184	716	32.8
	Баянхонгор	899	349	38.8
	Оюутолгой		927	-
	Ховд	1 138	159	13.9
	Улаангом	522	125	23.9
	Улаанбаатар	771	71	9.2
	<b>Нийт</b>	<b>11 071</b>	<b>2 572</b>	<b>23.2</b>
<b>МИАТ ТӨХК</b>	Оюутолгой	38 706	11 531	29.8
	<b>Нийт</b>	<b>38 706</b>	<b>11531</b>	<b>29.8</b>
<b>НИЙТ</b>		<b>85 480</b>	<b>18 240</b>	<b>21.3</b>

**График 9. Агаарын тээвэрлэгчдүүн орон нутагт зорчигч тээвэрлэсэн хувь**




Агаарын тээвэрээр орон нутагт нийт 18240 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 67240 зорчигч буюу 78.7%-иар буурсан бол өмнөх улирлаас 26103 зорчигч буюу 58.9%-иар буурсан байна. Орон нутагт Хүннү Эйр ХХК нь 4137 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 31566 буюу 88.4%-иар, Аэромонголиа ХХК 2572 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8499 зорчигч буюу 76.8%-иар, МИАТ ТӨХК нь 11531 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 27175 буюу 60.2%-иар тус тус буурсан. График 9-д Үндэсний агаарын тээвэрлэгч нарын орон нутагт зорчигч тээвэрлэсэн хувийг үзүүлэв.

### 3.3. Нислэгийн тоон үзүүлэлт

2021 I-III сар	2020 оны I улирал				2021 оны I улирал				2021.I/2020.I харьцуулалт ,
	Олон улсын хөө- рөлт буулт	Орон нутаг хөөрөлт буулт	Дамжин өнгөрөлт	Нийт	Олон улс хөө- рөлт буулт	Орон нутаг хөөрөлт буулт	Дамжин өнгөрөл т	Нийт	
1 сар	655	502	10300	11457	85	123	5452	5660	49.4
2 сар	346	437	5604	6387	70	139	4592	4592	71.9
3 сар	55	443	4791	5289	106	217	5447	5770	109.1
<b>НИЙТ</b>	<b>1056</b>	<b>1382</b>	<b>20695</b>	<b>23133</b>	<b>261</b>	<b>479</b>	<b>15491</b>	<b>16231</b>	<b>78.4</b>

Агаарын тээврээр дамжин өнгөрсөн нислэгийн тоо 2021 оны эхний улирлын байдлаар 15491 болж өмнөх оны мөн үеэс 5204 буюу 25.1%-иар, өмнөх улирлаас 2239 буюу 12%-иар тус тус буурсан байна. Олон улсын хөөрөлт, буултын тоо 261 болж өмнөх оны мөн үеэс 795 буюу 75%-иар, өмнөх улирлаас 50 буюу 16%-иар тус тус буурсан байна. Орон нутгийн хөөрөлт, буултын тоо 479 болж өмнөх оны мөн үеэс 903 буюу 65.3%-иар, өмнөх улирлаас 78 буюу 7.9%-иар тус тус буурсан байна. Дээрх тоон мэдээг өнгөрсөн онтой харьцуулан График 10-д харуулав.

График 10. Нислэгийн тоо үзүүлэлт



■ Орон нутгийн буулт, хөөрөлт ■ Олон улсын буулт, хөөрөлт ■ Дамжин өнгөрөлтийн тоо

# ТӨМӨР ЗАМЫН САЛБАР



## 4. Төмөр замын салбар<sup>9</sup>

### 4.1. Төмөр замаар тээвэрлэсэн ачаа тээвэрлэлт<sup>10</sup>

Үзүүлэлт	2020 I улирал	2021 I улирал	(мянган тонн) 2021.I/2020.I харьцуулалт %
<b>Тээвэрлэлсэн ачаа</b>	<b>7090.43</b>	<b>8132.70</b>	<b>114.7</b>
Дотоодод болон гадаадад тээвэрлэсэн (ачилт)	5637.06	6207.65	110.1
<i>Дотоодод</i>	<i>2537.54</i>	<i>3360.19</i>	<i>132.4</i>
<i>Гадаадад (заргалт)</i>	<i>3099.52</i>	<i>2847.46</i>	<i>91.9</i>
- ОХУ-д	43.04	54.64	126.9
- БНХАУ-д	3056.47	2792.83	91.4
<i>Гадаадаас (оруулалт)</i>	<i>615.29</i>	<i>888.04</i>	<i>144.3</i>
- ОХУ-аас	435.50	676.52	155.3
- БНХАУ-аас	179.79	211.52	117.6
<i>Дамжин өнгөрсөн</i>	<i>838.08</i>	<i>1037.01</i>	<i>123.7</i>
- ОХУ-аас БНХАУ-д	709.43	804.99	113.5
- БНХАУ-аас ОХУ-д	128.65	232.02	180.3
<i>Нүүрс</i>	<i>2614.66</i>	<i>2839.47</i>	<i>108.6</i>
- дотоодод	1984.72	2291.96	115.5
- гадаадад	627.94	547.51	87.2
Нефть, нефтийн бүтээгдэхүүн	131.77	76.26	57.9
Барилгын материал	129.64	630.10	486.0
үүнээс: цемент	61.26	119.42	194.9
балласт	8.75	350.17	4000.2
Мод. модон материал	25.16	20.58	81.8
үүнээс: дэр мод	4.64	3.81	82.1
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	45.65	64.67	
үүнээс: гурил. будаа	30.84	38.15	123.7
Түргэн муудах бүтээгдэхүүн	0.71	2.46	3.46
үүнээс: мах	0.50	2.35	470
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	68.95	62.37	90.4
үүнээс: үр тариа	24.05	43.31	180
арыс. шир. ноос	0.35	1.19	340
Уул уурхайн бүтээгдэхүүн	2466.21	2344.68	95.1
үүнээс: жонш. жоншны баяжмал	130.15	196.08	150.6
зэс болон молибдений	160.52	152.82	95.2
баяжмал			
төмрийн хүдэр	2117.69	1955.74	92.4
цайрын баяжмал	36.96	33.14	89.7
Хар төмөр (хаягдал. рельс г.м.)	55.24	55.98	101.3
Үйлдвэрийн машин. тоног төхөөрөмж.	3.0	5.38	
багаж хэрэгсэл			
Бусад	96.07	105.70	110

Дотоодод болон гадаадад тээвэрлэсэн ачаа. ачаны нэр төрөөр

<sup>9</sup> “ТТХЗНТ” УТҮГ-ын мэдээлэл

<sup>10</sup> “УБТЗ” ХНН-ийн Т-9 маягтын мэдээлэл

Төмөр замын тээврээр 2021 оны эхний улиралд Ковид-19 цар тахлаас үүдэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон зорчигч тээвэрлээгүй байна.

**График 11. Ачаа тээвэрлэлт, мян.тн**




Төмөр замын тээврээр 2021 оны эхний улиралд 8.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.0 сая тонн буюу 14.7%-иар өссөн байна. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны өсөлтөд дотоодын ачаа 822.6 мянган тонн буюу 32.4%-иар, импортын ачаа 272.7 мянган тонн буюу 44.3%-иар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Төмөр замын тээврээр тээвэрлэсэн ачаа 2021 оны 03 дугаар сард 3.0 сая тонн ачаа болж өмнөх сараас 455.4 мянган тонн буюу 18.1%-иар өссөн байна. Өмнөх жилүүдийн харьцуулалтыг График 11-т харуулав

Нийт ачаа тээвэрт орон нутгийн ачаа тээвэрлэлт 3360.19 мянган тонн буюу 41%, экспорт /гаргалт/ 2847.46 буюу 35%, импорт /оруулалт/ 888.04 мянган тонн буюу 11%, дамжин өнгөрсөн ачаа тээвэр 1037.01 мянган тонн буюу 13%-ийг тус тус эзэлж байна. Ачаа тээвэрлэлтийн статистик мэдээг График 12-оос үзнэ үү.

2021 оны эхний улирлын орон нутгийн ачаа өмнөх оны мөн үеэс 822.65 мянган тонн буюу 32.4%-иар, импорт өмнөх оны мөн үеэс 272.75 мянган тонн буюу 44.3%-иар, дамжин өнгөрсөн ачаа тээвэр өмнөх оны мөн үеэс 198.93 мянган тонн буюу 23.7%-иар тус тус өссөн боловч экспорт нь өмнөх оны мөн үеэс 252.06 мянган тонн 8.1% -иар буурсан.

**График 12. Ачаа тээвэрлэлт, мян.тн**



### Тээвэрлэсэн ачааны нэр төрөл

Төмөр замын тээврээр 2021 оны эхний улиралд тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 84.7%, барилгын материал 10.1%, хар төмөр 0.9%, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 1%, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 1%, мод модон материал 0.3% болон бусад бүтээгдэхүүн 1.8%-ийг эзэлж байна.

Төмөр замын тээврээр тээвэрлэсэн ачааг нэр төрлөөр нь авч үзвэл 2839.47 мян.тн нүүрс, 2344.68 мян.тн уул уурхайн бүтээгдэхүүн, 630.10 мян.тн барилгын материал, 76.26 мян.тн нефть, нефтийн бүтээгдэхүүн, 62.37 мян.тн ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, 64.67 мян.тн хүнсний бүтээгдэхүүн, 55.98 мян.тн хар төмөр, 20.58 мян.тн мод, модон материал, 2.46 мян.тн түргэн муудах бүтээгдэхүүн, 5.38 мян.тн үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, 105.7 мян.тн бусад ачаа тус тус эзэлж байна.

Төмөр замын тээврийн ачаа эргэлт 4657 сая тн.км болж, өмнөх оныхоос 210.26 сая тн.км буюу 4.7%-иар өссөн байна. Нийт ачаа эргэлтээс 817.88 сая тн.км буюу 18.4% нь орон нутагт, 2281.43 сая тн.км буюу 56.9% нь гаргалт, 406.85 сая тн.км буюу 9.1% нь оруулалт, 1151.09 сая тн.км буюу 25.9% нь дамжин өнгөрөлт эзэлж байна.

## 5. Бүх төрлийн тээврийн хэрэгслийн импортын мэдээ<sup>11</sup>

Барааны код	Барааны нэр	Импорт		Импорт		
		2020 оны эхний 3 сар	2021 оны эхний 3 сар	Тоо	Үнэ	
<b>17 Авто. агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл. тэдгээрийн эд. анги</b>						
<b>86 Төмөр замын буюу трамвайн зүтгүүр. хөдлөх бүрэлдэхүүн болон тэдгээрийн эд анги; төмөр зам буюу трамвай</b>						
8602	Төмөр замын бусад зүтгүүр. тендер.	.0	.0	2.0	27.5	
8604	Төмөр замын үйлчилгээний өөрөө явагч болон өөрөө явагч биш тээврийн хэрэгсэл.	11.0	48310.0	2.0	2420.0	
8606	Зөөврийн бусад өөрөө явагч биш вагон.	.0	.0	3.0	117.0	
8607	Төмөр замын зүтгүүр. хөдлөх бүрэлдэхүүний эд анги.	.0	.0	110.0	5137.0	
8608	Төмөр замын болон дохиоллын механик төхөөрөмж.	30453.0	5.44.5	9679.0	1479.5	
8609	Чингэлэг.	1479105.0	713.5	2791923.0	6268.1	
<b>Дүн</b>			670.0		356.0	

### 87 Бусад тээврийн хэрэгсэл. тэдгээрийн эд анги

8701	Трактор	46.0	988.4	51.0	414.1
8702	Нийтийн тээврийн моторт хэрэгсэл	444.0	3950.3	303.0	3828.5
8703	Суудлын автомашин	14242.0	69631.2	15099.0	91711.0
870321	Бензин хөдөлгүүртэй. цилиндрийн багтаамж нь 1000 см3-с ихгүй	20.0	36.2	22.0	122.0
870322	Бензин хөдөлгүүртэй. цилиндрийн багтаамж нь 1000-1500 см3 ихгүй	1547.0	3.956.7	1.010.0	3180.7
870323	Бензин хөдөлгүүртэй. цилиндрийн багтаамж нь 1500-3000 см3 ихгүй	1593.0	12785.9	1386.0	11536.1
870324	Бензин хөдөлгүүртэй. цилиндрийн багтаамж нь 3000 см3 -аас их	475.0	12830.8	584.0	22994.5
870331	Дизель хөдөлгүүртэй. цилиндрийн багтаамж нь 1500 см3-с ихгүй	4.0	12.6	.0	.0
870332	Дизель хөдөлгүүртэй. цилиндрийн багтаамж нь 1500-2500 см3-с ихгүй	25.0	148.3	39.0	289.3
870333	Дизель хөдөлгүүртэй. цилиндрийн багтаамж нь 2500 см3-с их	41.0	1499.4	162.0	6885.8
870340	Бензин-цахилгаан хосолсон хөдөлгүүртэй	10302.0	37664.8	11720.0	46053.1
870380	Зөвхөн цахилгаан хөдөлгүүртэй	26.0	212.3	19.0	262.5
8704	Ачааны автомашин	209.0	484.1	148.0	305.8
87042100	Дизель хөдөлгүүрт: Даац 5 тонноос ихгүй	4572.0	36493.0	6828.0	127172.8
87042200	Дизель хөдөлгүүрт: Даац 5-20 тонн	2845.0	5679.6	2646.0	6867.0
87042300	Дизель хөдөлгүүрт: Даац 20 тонноос их	353.0	2309.9	429.0	4003.0
87043100	Бензин хөдөлгүүрт: Даац 5 тонноос доош	500.0	13071.1	2746.0	88635.7
87043200	Бензин хөдөлгүүрт: Даац 5 тонноос их	796.0	2740.0	783.0	2173.9
8705	Тусгай зориулалтын автомашин	11.0	17.4	68.0	94.7
87051000	Автокран	146.0	3954.0	200.0	4475.0
87052000	Автомашинд сууринуулсан өрөмдөх төхөөрөмж	13.0	540.5	29.0	1345.1
87053000	Гал командын машин	2.0	688.7	.0	.0
87054000	Авто бетон зуурагч	4.0	15.2	12.0	597.8
87059000	Тусгай зориулалтын автомашин	25.0	536.9	63.0	920.4

<sup>11</sup> ГЕГ-ын 2021 оны эхний 3 сарын статистик мэдээлэл

## Зам, тээврийн салбарын 2021 оны 1 дүгээр улирлын статистикийн мэдээлэл

8706	Авто машины хөдөлгүүрт арал	102.0	2172.8	96.0	1611.7
8707	Тээврийн хэрэгслүүдийн бүхээг	98.0	134.4	149.0	.092.9
8708	Тээврийн хэрэгсэл. хөнгөн ба ачааны тэрэгний сэлбэг. эд анги	131516.0	7598.4	249332.0	8798.9
8709	Богино зайн зөөвөр хийх ачааны тэрэг. тэдгээрийн эд анги.	21.0	17.0	74.0	121.3
8711	Тэвштэй буюу тэвшгүй мотоцикл ба хөдөлгүүрт дугуй. дугуйт тэрэг.	5306.0	2848.6	6879.0	3821.0
8712	Унадаг дугуй.	2930.0	132.9	4.013.0	271.2
8713	Тахир дутуу хүмүүсийн мотортой буюу моторгүй тэрэг.	380.0	20.6	192.0	30.0
8714	Мотоциклъ. дугуй. тахир дутуу хүмүүсийн тэрэгний эд анги. тоног хэрэгсэл.	218.0	5.1	13.837.0	53.9
8715	Хүүхдийн тэрэг. түүний эд анги.	570.0	18.3	2.040.0	72.7
8716	Чиргүүл. хагас чиргүүл. өөрөө явагч биш бусад тээврийн хэрэгсэл. эд анги.	16130.0	8750.2	18828.0	81886.6
<b>Дүн</b>		<b>134542.5</b>		<b>323749.9</b>	

### 88 Агаарын хөлөг, сансрын хөлөг болон тэдгээрийн эд анги

8801	Агаарын бөмбөлөг. нисдэг аппарат.	1901.0	17.6	.0	.0
8802	Агаарын тээврийн хэрэгсэл	.0	.0	3.0	6422.2
8803	Нисдэг аппарат. агаарын тээврийн хэрэгслийн эд анги.	289.0	931.3	698.0	249.5
8805	Онгоцыг хөөргөх буулгах аппарат хэрэгсэл. тэдгээрийн эд анги	.0	.0	3.0	1.8
<b>Дүн</b>		<b>948.9</b>		<b>6673.5</b>	

Гаалийн Ерөнхий газрын статистик мэдээллээс харахад 2021 оны эхний 3 сард импортоор орж ирсэн тээврийн хэрэгсэл. түүний эд ангийн импортын үнийн дүн өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн байна. Жишээлбэл импортоор 15099 суудлын автомашин орж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 857 суудлын автомашинаар буюу 6%-иар өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлтөд бензин-цахилгаан хосолсон хөдөлгүүртэй авто машин 11720 болж 13.7%-иар өссөн нь нөлөөлжээ.

Тээврийн хэрэгсэл. хөнгөн ба ачааны тэрэгний сэлбэг эд анги өмнөх оны мөн үеэс 89.6%-иар. дизель хөдөлгүүрт/даац 5тонноос доош/ 49.3%-иар. мотоцикл 29.6%-иар. унадаг дугуй 36.9%-иар. чиргүүл 16.7%-иар. трактор 10.8%-иар. бензин хөдөлгүүрт/даац 5 тонноос доош/ 5 дахин. мотоциклъ. дугуй. тахир дутуу хүмүүсийн тэрэгний эд анги. тоног хэрэгсэл өмнөх оны мөн үеэс 63 дахин тус тус нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь Монгол Улс үйлдвэрлэгч орон биш учраас эдгээр бараа. бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлага өндөр байсаар байгаа нь статистик мэдээллээс харагдаж байна.

## II. ДҮГНЭЛТ

Зам. тээврийн салбар 2021 эхний улиралд бүх төрлийн тээврээр нийт 17.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2 сая тонн буюу 70.5%-иар өссөн. Үүнээс автотээврээр тээвэрлэсэн ачаа 3 дахин. төмөр замаар тээвэрлэсэн ачаа 14.7%-иар өсч, агаарын тээврийн ачаа 32.5%-иар буурсан байна.

Зам, тээврийн салбарын эхний улирлын байдлаар статистик мэдээллийг үзэхэд ковид-19 цар тахлын улмаас Монгол Улс 2020 оны эхний улиралд хатуу хөл хорио тогтоон хилээ хааснаар ачаа болон зорчигч тээвэрлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар огцом буурсан үзүүлэлтийг бүтэн жилийн хугацаанд тээврийн салбар нь багагүй бэрхшээлийг туулж үйл ажиллагаагаа тогтвортой, найдвартай явуулахын тулд цаг алдалгүй шуурхай ажиллаж, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрч чадлаа.

2021 оны эхний улирлын тээврийн нийт орлого 352.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 40.8 тэрбум төгрөг буюу 13.1%-иар өссөн бол өмнөх улирлаас 98.1 тэрбум төгрөг буюу 21.8%-иар буурсан байна. Нийт орлогын 54.2%-ийг төмөр зам, 38.6%-ийг автотээвэр, 7%-ийг агаарын тээврийн салбар тус тус бүрдүүлсэн байна.

Бүх төрлийн тээврээр зорчигчид давхардсан тоогоор 19.8 сая хүн болж өмнөх оны мөн үеэс зорчигч 9.3 сая хүн буюу 30.4%-иар буурсан байна. Үүнээс төмөр замын тээврээр 2021 оны эхний улиралд зорчигч тээвэрлээгүй, агаарын тээврийн зорчигч 88.3%-иар, автотээвэр 30.4%-иар тус тус буурсан. Гадаад болон дотоод зорчигч тээвэрлэлтийн хөдөлгөөнийг хязгаарласан нь зорчигч тээвэрлэлтийн бууралтад шууд нөлөөлсөн.

Монгол Улсад хөл хорио 2020 оны 11-р сарын 11-с 12-р сарын 15-ны өдөр хүртэл 35 хоног, 2020 оны 12-р сарын 23-с 2021 оны 1-р сарын 11-ний өдөр хүртэл 19 хоног, 2021 оны 2-р сарын 11-с 2-р сарын 23-ны өдөр хүртэл 41 хоног, мөн оны 4-р сараас 10-наас 25-ны өдөр хүртэл 16 хоног хэрэгжсэн байна. Хагас жилийн хугацаанд нийт 111 өдөр хөл хорио тогтоосон нь эдийн засгийн салбаруудын хувьд ялангуяа тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл багагүй тулгарч байна.

Тээврийн салбарт ковид-19 цар тахлын улмаас дараах сөрөг үр дагавар бий болсон. Үүнд улсын хил хааснаар улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлт багасаж олон улсын худалдаа, тээвэр буурч, аялал жуулчлал зогссон. Харин дотооддоо хот хооронд, аймаг хооронд, хот дотор ачаа, зорчигчийн хөдөлгөөний хязгаарлалт хийгдсэнээр худалдан авах чадвар буурах, бараа бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлт багасах зэрэг сөрөг үр дагаврууд бий болсон.

Дэлхийн улс орнууд ковид-19 цар тахлын даван туулахаар вакцинжуулалтад иргэдээ хамруулж байна. Иймд нэн түрүүнд ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтад бүх нийтээрээ хамрагдаж өвчлөлийн тоог бууруулахад онцгой анхаарах хэрэгтэй. Цаашид тээврийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой үргэлжлүүлэх бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө гаргах ажиллах зүйтэй.

Ковид-19 цар тахал хэдийгээр эдийн засгийн салбаруудад тэр дундаа тээврийн салбарт илүү ихээр нөлөөлж, сөрөг үр дагавар үзүүлж байсан ч тээвэр зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулах боломжийг олгож, хүнд нөхцөл байдалд дасан зохицох, тогтвортой ажиллах чадамжийг бий болгохыг шаардаж байгааг харуулж байна. Цаашлаад дижитал платформруу шилжих нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд зам, тээврийн салбарын үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх, хил гаалийн тээврийн баримт бичгийг цахимжуулах, хөнгөвчлөхөд анхаарал хандуулах нь зүйтэй байна.

### ӨНГӨНИЙ КОД

➤ ЕРӨНХИЙ БОЛОН НЭГТГЭСЭН МЭДЭЭЛЭЛ

➤ АВТО ЗАМ

➤ АВТОТЭЭВЭР

➤ ТӨМӨР ЗАМ

➤ ИРГЭНИЙ НИСЭХ

➤ УСАН ЗАМ

Боловсруулсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар  
2021.04.20